



СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Г. ХУРЦБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум 14 баг  
Утас:70-37-30-89, Факс: (976)70-37-30-89  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2017.02.17 № 117  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Статистикийн хэлтсийн 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн болон тайлбар тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын системийг горим сорилоор шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Статистикийн хэлтсийн 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тайлбар тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. ЧҮЛТЭМБАТ

001084